

**ГААЛИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ДАРГА С.ЦЭРЭНЧИМЭДИЙН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025.06.13

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ЗОРИЛТОТ ТҮВШИН	БИЕЛЭЛТ
<b>Нэг. Гаалийн төв лабораторийн чиглэлээр</b>				
1	Бараанд гаалийн зорилгоор магадлан шинжилгээ хийх, барааны нэр төрөл, аинглалын кодыг тодорхойлох, дүгнэлт гарах	1.Хураамжийн орлогын төлөвлөгөө төгрөгөөр, хувиар 2.Зөрчил илрүүлэлт, тоогоор	1. Улсын төсөвт өөрийн орлого /шинжилгээний хураамж/ 350 сая төгрөгийг төвлөрүүлэх 2. Шинжилгээний үр дүнгээр илрүүлсэн зөрчил.	<p><b>Магадлан шинжилгээ:</b>          ГТЛ нь 2025 оны эхний хагас жилийн (2025.01.02-06.13-) ны байдлаар 17 гаалийн газар, хорооноос ирүүлсэн 1356 аж ахуйн нэгж болон иргэний (давхардаагүй тоогоор) 5843 дээжийг шинжилгээнд хамруулж, 3286 дүгнэлт гаргасан. Нийт дээжний 89.99% буюу 5258 дээжийг өөрөө шинжилсэн.          Үүний 1428 дүгнэлт нь (43.5%) экспорт, 1858 дүгнэлт нь (56.5%) импортын бараанд хамаарч байна. Шинжилгээний хураамжаар төгрөгийн хураамж оруулсан байна.  <b>Албан хүсэлтээр:</b> Тайлант хугацаанд нийт 87 албан хүсэлтээр 328 дээжинд магадлан шинжилгээ хийж, ангиллын код тодорхойлж, хариу хүргүүлсэн бөгөөд улсын төсөвт орлого оруулсан.          Гийн шинжилгээний хураамжаар улсын төсөвт сая төгрөгийг оруулсан байна.  <b>Хураамжийн төлөвлөгөөний биелэлт: 108,1%</b></p> <p><b>Салбар лабораториуд:</b>          2025 оны 2-р улирлын байдлаар хилийн боомтууд дээр ажиллаж байгаа гаалийн 8 салбар лабораториуд нь нийт 13759 дээжинд магадлан шинжилгээг холбогдох стандартын дагуу хийж, 9800 дүгнэлт гаргаж, 141 зөрчил илрүүлж, шинжилгээний хураамжаар төгрөгийг улсын төсөвт оруулсан.          Нийт гаалийн зорилгоор 5124 дээжид магадлан шинжилгээг хийж 4560 дүгнэлт, хорио цээрийн чиглэлээр 8635 дээжид магадлан шинжилгээг хийж 5240 дүгнэлтийг тус тус гаргаж ажилласан байна. Нийт дээжний 62,76%-ийг хорио цээрийн дээж эзэлж байна.          Нийт 9800 дүгнэлт гаргаснаас 2483 дүгнэлт буюу 25.3% нь экспорт, 7317 дүгнэлт буюу 74.7% нь импортын барааны дүгнэлт байна.</p>

## **2. Илрүүлсэн зөрчил:**

ГТЛ-ийн шинжилгээний дүнгээр 49 ААН-ийн 52 дээжинд зөрчил илэрсэн. Нийт зөрчлийн 98%-ийг барааны ангиллын кодыг буруу мэдүүлсэн зөрчил эзэлж байна. Зөрчлийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.7%-иар буурсан нь ААН-үүдийн хууль сахилтын түвшин сайжирч байгаатай холбоотой.

Тайлангийн хугацаанд гаалийн салбар лабораториудын магадлан шинжилгээний үр дүнгээр 141 дээжинд зөрчил илэрсэн. Үүнээс: хорио цээртэй холбоотой зөрчил- 56, Барааны ангиллын код зөрсөн- 83, тусгай зөвшөөрөл шаардлагатай зөрчил-2 эзээлж байна. Зөрчлийн тоо 7 буюу 4,7 хувиар буурсан.

## **Хурсэн дун:**

ГТЛ-ийн 2025 оны эхний хагас жил (2025.01.02-06.13)-ны байдлаар хийгдсэн магадлан шинжилгээний тоон үзүүлэлтийг өмнөх 2024 оны мөн үетэй харьцуулахад дээжний тоо 24%, дүгнэлтийн тоо 39.82%-иар буурсан, харин шинжилгээний хураамж төгрөг буюу 28.4%-иар буурсан үзүүлэлттэй ошина. Магадлан шинжилгээний тоон үзүүлэлт буурсан нь ШХГГ болон ГСГГ-ОТ дахь салбар лабораториуд хэвийн ажилласантай холбоотой.

ГСЛ-ын 2025 оны 2-р улирлын магадлан шинжилгээний тоон үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дээжний тоо 1634 буюу 13,47 хувиар, дүгнэлтийн тоо 2392 буюу 32,3 хувиар өссөн, зөрчлийн тоо 7 буюу 4,7 хувиар буурсан ба шинжилгээний хураамжаар төгрөг буюу 41 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд гаалийн төв болон салбар лабораториуд нь нийт 19602 дээжинд магадлан шинжилгээ хийж, 13086 дүгнэлт гаргаж, төгрөгийг улсын төсөвт оруулсан байна.

Магадлан шинжилгээний тоон үзүүлэлтийг 2024 оны мөн

			<p>үетэй харьцуулахад дээжний тоо 1,05-иар буурч, дүгнэлтийн тоо 1,1%-иар нэмэгдэж, хураамжийн хэмжээ 7,7%-иар буюу төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Хураамжийн хэмжээ өссөн нь салбар лабораториуд сайн ажилласантай холбоотой.</p> <p><b>2. Илрүүлсэн зөрчил:</b> Тайлант хугацаанд Гаалийн төв болон салбар лабораториуд нь магадлан шинжилгээний үр дүнгээр 193 зөрчлийн илрүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гаалийн төв лабораторийн магадлан шинжилгээний үр дүнгээр 49 аж ахуй нэгжийн 52 дээжинд зөрчил илэрсэн. Нийт зөрчлийн 98%-ийг барааны ангиллын кодыг буруу мэдүүлсэн зөрчил эзэлж байна.</li> <li>- Гаалийн 9 салбар лабораториуд нь магадлан шинжилгээний үр дүнгээр нийт 141 зөрчлийг илрүүлсэн. Үүнээс: хорио цээртэй холбоотой зөрчил 56, Барааны ангиллын код зөрсөн зөрчил 83, тусгай зөвшөөрөл шаардлагатай зөрчил 2 байна.</li> </ul> <p>Гаалийн төв болон лабораторийн илрүүлсэн зөрчлийг өнгөрсөн үеийн мөн үетэй харьцуулахад 23 буюу 10,65%-иар буурсан байна. Үүнээс үзэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хууль сахилтын түвшин сайжирсан байна.</p> <p><b>Биелэлт: 100%</b></p>
2	Төв болон Салбар лабораторийг бэхжүүлэх, чадавхжуулах, салбар лабораторийг шинээр байгуулах чиглэлээр санал өгөх төсөл боловсруулах, хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	<p>Төв болон салбар лабораториудыг бэхжүүлэх, чадавхжуулах, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авч ажиллах</p> <p>1.1. ЗҮГГ-ын салбар лабораторийн барилгын шинжилгээний өрөөг нүүрс болон ноос ноолуурын шинжилгээний чиглэлээр өөрчлөх засварын ажлыг хийж гүйцэтгэх тендерийг зарлах, хяналт тавьж засвар үйлчилгээний ажлыг эхлүүлэх</p> <p>1.2. СЭГГ-ын салбар</p> <p>Төв болон салбар лабораториудыг бэхжүүлэх, чадавхжуулах, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:</p> <p>1.1 ЗҮГГ-ын салбар лабораторийн хуучин барилгыг нүүрсний болон ноос ноолуур, ширхэгт материалын шинжилгээний зориулалттай болгон барилгын засварлах зураг төслийг боловсруулж, баталгаажуулан хүргүүлсэн.</p> <p>ХББОСЯ-аас Гаалийн байгууллагад тавьсан саналын дагуу импортын барилгын материалын чанар, аюулгүй байдлыг хангах төслийн хүрээнд Замын-Үүд боомтын “Авто замын шалган нэвтрүүлэх цогцолбор 2”-т баригдсан барилгын материал шинжлэх зориулалттай лабораторийг ашиглалтад оруулах талаар ХББОСЯ-д ГЕГ-ын 2025.05.30-ны 02/2315 тоот албан бичгийг хүргүүлж ажилласан.</p>

		<p>лабораторийн хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар аюулгүй байдал, хорио цээрийн шинжилгээний тоног төхөөрөмжийг суурилуулах</p> <p>1.3. ГСГГ-ын боомт дахь салбар лабораторийг БСҮХороотой хамтран нүүрс болон хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар аюулгүй байдал, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр өөрчлөн засварлах</p> <p>2. Лабораторийн мэдээллийн менежментийн нэгдсэн систем (LIMS) Гаалийн төв болон салбар лабораторийн LIMS программыг хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр өргөжүүлэлт хийх</p>	<p>1.2 СЭГГ-ын салбар лабораторийн барилга 2025 онд 1 сард ашиглалтанд орсонтой холбогдуулан 2025 оны 2-р сараас хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар аюулгүй байдал, хорио цээрийн шинжилгээний тоног төхөөрөмжийг суурилуулж тохигоог хийж,</p> <p>ХББОСЯ-аас тавьсан саналын дагуу Импортын барилгын материалын чанар, аюулгүй байдлыг хангах төслийн хүрээнд Алтанбулаг дахь салбар лабораторийн барилгын зураг төсөлд орох нэмэлт өөрчлөлтийг түргэвчлэх, магадлалаар оруулж батлуулах, агааржуулалтын систем, цэвэр, бохир усны шугам, цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх холбогдох өөрчлөлтийг яаралтай хийж гүйцэтгүүлэх талаар тодорхой арга хэмжээг авч, анхаарч ажиллах талаар ГТЛ-иос 2025.05.19-ний 02-2.3/462, ГЕГ-ын 2025.05.30-ны 02/2315 тоот албан бичгүүдийг хүргүүлж ажилласан.</p> <p>1.3 ГСГГ-ын салбар лабораторийн барилгын зураг төсөлд нүүрс, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээний тоног төхөөрөмжийг байрлуулан, агааржуулалт, цэвэр бохир ус, цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэн холбогдох өөрчлөлт оруулж, зураг төслийг баталгаажуулан, БХБОСЯ-нд магадлалыг хийлгэж, Боомтын сэргэлтийн үндэсний хороонд хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас ГСГГ-ын салбар лабораторийн барилгын засварын болон хүнс, хорио цээрийн лабораториудад шаардлагатай лабораторийн зориулалттай тавилга, тоног хэрэгслийн тестер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулан, барааг нийлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>1.4. ДоГГ-ын салбар лабораторийн шинжилгээний нэр төрлийг хорио цээрийн чиглэлээр өргөжүүлэх хүрээнд лабораторийн барилгын 1 болон зоорийн давхарын зураг төсөлд өөрчлөн оруулах ажлыг ДОГГ-ын салбар лабораторитой хамтран гаргасан.</p> <p>2. ГТЛ болон "Санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ-тай хамтран Лабораторийн мэдээллийн менежментийн нэгдсэн систем (LIMS)-ийг өргөжүүлэлт, сайжруулалтын 01 дугаартай төлөвлөгөөг боловсруулан баталж, мөрдөн ажиллаж байна.</p> <p>LIMS программыг хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр өргөжүүлэлт хийж,</p>
--	--	---	---

				<p>соролтын дүнг гаргаж байна.</p> <p>3. Гаалийн салбар лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангуулах хүрээнд “ГЕГ болон ХХК-тай 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан ГЕГ47/24 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу ГТЛ-ийн 8 шинжээч-ГУБ нар итгэмжлэгдсэн лабораториид гаалийн зорилгоор магадгын шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллалаа.</p> <p><b>Биелэлт: 90%</b></p>
3	Гаалийн төв болон салбар лабораториудын итгэмжлэлийн хүрээ өргөтгөл, чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилт, гадаад, дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулах, ур чадварын хөтөлбөрт хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	<p>1. Гаалийн төв лабораторийн хувьд:</p> <p>1.1. Үндэсний итгэмжлэлийн үнэлгээний байгууллага /MNAS/-аар итгэмжлэлийн эрхээ сунгуулах, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр хүрээг өргөтгөх</p> <p>1.2. БНХАУ-ын итгэмжлэлийн үнэлгээний байгууллага /CNAS/-ын хяналтын үнэлгээнд хамрагдаж, итгэмжлэлийн эрхээ баталгаажуулах.</p> <p>2. Гаалийн салбар лабораториудын хувьд:</p> <p>2.1. Үндэсний итгэмжлэлд ЗҮГГ, ОРГГ, СШГГ-ын гаалийн салбар лабораториудыг химийн бодис, бэлдмэл, эрдэс түүхий эд, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний чиглэлээр үндэсний итгэмжлэлд хамруулах.</p>	<p><b>1. Гаалийн төв лабораторийн хувьд:</b></p> <p>1.1. 2025.06.03-04 өдрүүдэд Үндэсний итгэмжлэлийн төв (MNAS) болон Ази номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APAC)-ын хамтарсан “Гаалийн төв болон салбар лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, хар тамхи мансууруулах бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, ээрмэл, сүлжмэл материалын шинжилгээний чиглэлээр давтан итгэмжлүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт, ургамал хорио цээрийн шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөх” үнэлгээнд амжилттай хамрагдав. Урьдчилсан дүнгээр 2 үл тохиролтойгоор тэнцсэн бөгөөд уг үл тохиролыг запруулан, баритжуулж, “Үл тохиролыг запруулсан тухай тайлан” (23 хуудас )-г ГТЛ-ийн 2025.6.13-ны өдрийн 02-2.3/534 дугаар албан бичгээр Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлсэн болно. 2025.6.16-ны өдрийн УИТ-ийн техникийн хорооны хурлаар хэлэлцэж итгэмжлэлийн эрхийг сунгаж, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр хүрээг өргөтгөх шийдвэр гарсан.</p> <p>1.2 Гаалийн төв лаборатори нь уул уурхайн худэр баяжмал, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний чиглэлээр БНХАУ-ын Итгэмжлэлийн байгууллага болох CNAS (China National Accreditation Service for Conformity Assessment)-ийн хяналтын давтан үнэлгээнд 2025 оны 4 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд амжилттай хамрагдаж, итгэмжлэлийн эрхээ баталгаажуулсан.</p>

			<p><b>2. Гаалийн салбар лаобраториудын хувьд:</b></p> <p>Гаалийн 12 салбар лабораторийг эрдэс түүхий эд, нүурс, нүүрсэн бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, хар тамхи мансууруулах бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, ээрмэл, сүлжмэл материал, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт болон ургамал, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг салбар тус бүрээр гаргаж, ҮИТ-ийн техникийн хорооны хурлаар орж, итгэмжлэлийн бичиг баримтаар амжилттай итгэмжлүүлэхээр шийдвэрлэгдсэн.</p> <p><b>Хүрсэн үр дүн:</b></p> <p>1.1 ГТЛ нь эрдэс түүхий эд, нүурс, нүүрсэн бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бэлдмэл, хар тамхи мансууруулах бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхин бүтээгдэхүүн, ноос ноолуур малын гаралтай ширхэгт бүтээгдэхүүн, ээрмэл, сүлжмэл материалийн шинжилгээний чиглэлээр Үндэсний итгэмжлэлийн эрхээ 4 жилийн хугацаатайгаар/ 2025-2029 он/ амжилттай сунгасан.</p> <p>ГТЛ нь хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт болон ургамал, хорио цээрийн шинжилгээний шинэ арга, аргачлал нэвтрүүлэн, хэрэгжүүлж ажилласнаар итгэмжлэлийн хүрээг амжилттай өргөтгөв.</p> <p>1.2 ГТЛ нь уул уурхайн хүдэр баяжмал, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний чиглэлээр БНХАУ-ын итгэмжлэлийн хяналтын үнэлгээнд амжилттай хамрагдан, итгэмжлэлийн эрхээ хамгаалж баталгаажуулсан.</p> <p>2. Гаалийн 12 салбар лабораториудыг итгэмжлэлийн бичиг баримтаар 4 жилийн хугацаатайгаар /2025-2029он/ амжилттай итгэмжлүүлэхээр шийдвэрлэгдсэн.</p> <p style="text-align: center;"><b>Биелэлт: 100%</b></p>
4	Төв болон салбар лабораторийг мэргэшсэн чадварлаг боловсон хүчингээр	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	Гаалийн төв болон салбар лабораторийн боловсон хүчнийг бэлтгэх, шинжээчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, сургалтад хамруулах 2025 оны төлөвлөгөө боловсруулан

<p>хангах, бэлтгэх, холбогдох сургалтуудыг зохион байгуулах гадаад, дотоод сургалтанд хамруулж мэрэгшүүлэх</p>	<p>дээшлүүлэх, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, сургалтад хамруулах төлөвлөгөө боловсруулан батлуулах</p>	<p>2025.01.23-ны өдрийн 01720/3 тоот дотоод зурвасаар ГЕГ-ын СТ-д хүргүүлсэн. Тайлант хугацаанд нийт 23 сургалт зохион багуулагдсанаас танхимын 6 сургалт, гадаад-2, ажлын байрны-4, харьяа гаалийн газар, хороодод-11 эзэлж байна</p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Сургалтад хамрагдсан байдал:</b></li> <li>1.1. ГУБ-Шинжээч Э.Алтанзул Нүүрсний шинжилгээний хэсэгт 14 хоног дадлагажин ажиллаж, нүүрсний иж бүрэн шинжилгээг бие даан шинжлэх ур чадварыг эзэмшив.</li> <li>1.2. 2025.01.07-08 хооронд ГУАБ Б.Мөнхцацral, ГУБ Д.Мөнхтөр нар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу АЗ сургалт”- д хамрагдаж, 2025.01.10-ны өдөр шалгалтыг амжилттай өгч, тэнцэв.</li> <li>1.3. ЭБАУЯ болон Монголын химичдын холбооноос зохион байгуулсан “Химийн инженерийн зөвлөх зэрэг олгох сургалтанд ГТЛ-ийн дарга С.Цэрэнчимэд, ГУБ-шинжээч Отгонбаяр дарга амжилттай хамрагдаж мэргэжлийн зэрэг дэвээ ахиуллаа.</li> <li>1.4. 2025.03.13-14 хооронд Гаалийн төв лабораторийн Ахлах шинжээч-ГУАБ П.Мөнх-Эрдэнэ, шинжээч-ГУБ С.Баярдулам, Н.Ганзориг нарыг “Монголын Цацрагийн Хамгаалалтын Нийгэмлэг”-ээс зохион байгуулсан “Рентген шинжилгээний тоног төхөөрөмжж ашиглалт- Цацрагийн хамгаалалт” сэдэвт сургалтад амжилттай хамруулж, гэрчилгээ гардан авав.</li> <li>1.5.</li> <li>1.6. Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын сургалтанд ГУАБ Мөнх-Эрдэнэ</li> </ol>
--	--	---

			<p>1.7. Солонгосын “К—Петро” компани болон АМГТГ-аас зохион байгуулсан нүүрсний болон газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний сургалт /ГТЛ, СШГГ, ДОГГ-ын нийт 6 шинжээч/</p> <p>1.8. Медимпекс ХХК-тай хамтран хүнсний хими хор судлал, пестицидын чиглэлээр сургалт/ ГТЛ, СЭГГ, ЗҮГГ, ЧХОУНБГ-ын нийт 10 шинжээч/</p> <p>1.9. Ажлын байрны сургалтыг Хүнсний бүтээгдхүүнд хүнд металл тодорхойлох сургалтын Шинжээч Ганзориг явуулсан. Уг сургалтад ГТЛ, СЭГГ, ЗҮГГ, ЧХОУНБГ-ын нийт 10 шинжээчид оролцсон.</p> <p>1.10. Лайфтроник компанийт хамтран VIDAS KUBE болон VITEX 2 COMPACT төхөөрөмж дээр хүнсний бүтээгдэхүүний хордлого үүсгэгч нянг илрүүлэх болон оношлох аргын онолын болон дадлагын сургалт / ГТЛ, СЭГГ, ЗҮГГ, ЧХОУНБГ-ын 8 шинэээч /</p> <p>2. <u>Сургалт зохион байгуулсан байдал:</u> Дараах сургалтуудад “Гаалийн зорилгоор магадлан шинжилгээ хийх, Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам” сэдвээр ГТЛ-ийн дарга С.Цэрэнчимэд, 2025.02.13нд ГУАБ Б.Мөнхцацрал нар сургалт явууллаа. Үүнд:</p> <p>2.1. 2025.01.31, 2025.02.13, 2025.05.30, 2025.06.20-ны өдрүүдэд УБГГ, ЧХОУНБГГ, УХШИГГ-ын хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн хяналт хариуцсан ГУБ нар /88 хүнд 4 цаг/</p> <p>2.2. 2025.02.20нд Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалт /80 хүнд 2 цаг/</p> <p>2.3. 2025.03.27нд ТАЗ-ийн тусгай сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдэд Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт /45 хүнд 2 цаг/</p> <p>2.4. 2025.02.20, 2025.04.09, 2025.04.30, -2025.05.19-ны өдрүүдэд Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэний анхан болон давтан сургалт /80 бүртгэгдсэн мэргэжилтэн/</p> <p>2.5. ЧХОУНБГ-ын гаалийн салбар лабораторийн шинжээч ГУБ нарт зориулсан 2025.05.12-23</p>
--	--	--	---

				<p>хооронд буюу 14 хоногийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, ГТЛ-ийн удирдлагаар батлуулж, ажлын байрны сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Дээрх сургалтуудад 213 ГУБ, гаалийн харьцаанд оролцогч нар оролцсон.</p> <p><b>Биелэлт: 100%</b></p>
5	Төв болон салбар лабораторийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт, урвалж бодисын нийлүүлэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	<p>1. Төв болон салбар лабораторийн тоног төхөөрөмжийн оношилгоо, засвар, үйлчилгээг хийлгэх, хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулах,</p> <p>2. 2025 онд шаардлагатай урвалж бодис, стандарт дээж, шил сав, туслах хэрэгслийг жагсаалт гаргах, тендерийг зарлах.</p>	<p>1. ГТЛ-ийн газрын тос, нүүрсний шинжилгээний тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг холбогдох нийлүүлэгч компаниудын инженер, техникийн ажилчдаар оношуулан, засварлаж, хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан.</p> <p>Төв болон салбар лабораториид суурилагдсан шинжилгээний тоног төхөөрөмжүүдийн ашиглалтад хяналт тавьж, засвар үйлчилгээг тухай бүр хийж ажилласан.</p> <p>2. 2025 онд улсын төсвийн урсгал зардлаар Гаалийн төв болон салбар лабораториудын шинжилгээнд шаардлагатай урвалж бодис, стандарт дээж, шил сав, туслах хэрэгслийдийн жагсаалтыг шинжилгээний чиглэл тус бүрээр гаргаж, СХОГ-т хүргүүлж, худалдан авах ажиллагааг СХОГ-тай хамтран зохион байгуулж ажиллаж байна. Уг үнэлгээний хорооны ажлын хэсгийн даргаар ГТЛ-ийн дарга С.Цэрэнчимэд, гишүүнээр ГУБ С.Баярдулам нар ажилласан.</p> <p>3. ГЕГ-ын 2025.01.14-ний өдрийн А/09 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулан, нээлттэй тендерийг 8 багцаар зарласан. Нээлттэй тендерийг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим сайгад байршуулж ажилласан. Уг тендерт ирүүлсэн ААН-ийн материал хангалттгүй байсан тул тендер амжилтгүй болж, 2025.05.26-ны өдөр багц болгоныг нарийвчлан гаргаж, 15 багц болгож тендерийг дахин зарласан. Тендер 2025.06.17-ны өдөр нээнэ.</p> <p>4. CNAS-ийн давтан итгэмжлэл болон МҮ-ын Үндэсний итгэмжлэлд хамрагдах зорилгоор ГТЛ-д ашиглагдаж</p>

				<p>буй 38 туслах ба хэмжих хэрэгслүүдийг мэргэжлийн байгууллагуудаар баталгаажуулж, шалгалт тохируулгад хамруулж ажилласан.</p> <p>5. ГТЛ-ийн баталгаажуулалтад хамруулах 32 нэр төрлийн хэмжих хэрэгслийн жагсаалтыг гаргаж 2025.01.27-ны өдрийн 02-2.3/0117 тоот албан бичгээр СХЗГ-т хүргүүлэн, 3 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулалтад хамруулж, гэрчилгээ авсан.</p>
6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	<ol style="list-style-type: none"> <li>“Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-нд ГТЛ-ийн хэрэгжүүлэх ажлыг тусгуулах</li> <li>Хүнсний бүтээгдэхүүний нян судлал, хими хор судлал, ургамал хорио цээрийн шинжилгээний хураамжийн төслийг шинэчлэн боловсруулах бэлтгэл ажлыг ханган ажиллах</li> </ol>	<p><b>Биелэлт: 100%</b></p> <p>1. Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэгт Чанарын менежер ГУАБ Б.Мөнхцацрал ажилласан бөгөөд гаалийн төв болон салбар лабораториудын бодит байдлыг тодорхойлж, стратеги төлөвлөгөөний санал боловсруулж, 223 тоот дотоод зурвасаар хүргүүлсэнээр “Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-д тусгуулж батлуулсан.</p> <p>2. Чанарын менежментийн тогтолцооны холбогдох бичиг баримт болох ЧГА түүний журмуудыг нягтлан, тэдгээрт тусгагдсан хууль, журам, тогтоол, шийдвэрийн шинэчлэгдсэн эсэхэд шүүлт хийн ажилласан. Шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулан, ажилласан. Хүнсний бүтээгдэхүүний нян судлал, хими хор судлал, ургамал хорио цээрийн шинжилгээний тоног төхөөрөмжийн болон шинжилгээний аргын 40 гаруй САЗ-ыг шинээр боловсруулж, ГТЛ-ийн даргаар батлуулсан.</p> <p>3. ЗҮГГ-ын салбар лабораторийн хамтран хүнсний бүтээгдэхүүний нян судлал, хими хор судлал, ургамал хорио цээрийн шинжилгээний нийт 235 үзүүлэлт тус бүрээр зарцуулагдаж байгаа урвалж бодис, цахилгааны зарцуулалт, шил сав болон тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдол, шинжээчдийн цалин зэргийг тусган шинжилгээний хураамжийг шинэчлэл үндэслэлийг гаргаж, одоо мөрдөгдэж байгаа хураамжтай харьцуулан судалгаа хийж, шинжилгээний хураамжийг шинэчлэн гаргаж, МХЗ-аар оруулж батлуулах бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p><b>Биелэлт: 100%</b></p>

7	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол, 2016 оны 81-р тогтоол, 2019 оны 342 ба 465 -р тогтоолууд, 2021 оны 174-р тогтоол, 2022 оны 362-р тогтоол, 223-р тогтоол болон ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан холбогдох журмуудыг мөрдөн, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллах.</p> <p>2. Ил тод байдлыг ханган ажиллах</p>	<p>Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Гаалийн лабораторийн магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах үйл ажиллагаанд Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол, 2016 оны 81-р тогтоол, 2019 оны 342 ба 465 -р тогтоолууд, 2021 оны 174-р тогтоол, 2022 оны 362-р тогтоол, 223-р тогтоол болон ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан холбогдох журмуудыг мөрдөн, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласан.</li> <li>2. 2025.01.24-ний өдөр Сангийн Яаманд “Гаалийн төв болон салбар лабораториудад 2020-2024 оны хооронд хийгдсэн нийт магадлан шинжилгээний үр дүнгээр илэрсэн зөрчилүүдийн мэдээлийг, түүний 83.32% буюу 1'324 бараанд гаалийн, 16.68% буюу 265 бараанд хорио цээрийн зөрчил илэрсэн байгаа тухай мэдээлэл хүргүүлэв.</li> <li>3. Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ГЕГ-ын ажлын хэсгийн уулзалтад 2025.02.04, 09, 11-ний өдрүүдэд оролцож, лабораторийн магадлан шинжилгээтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Сангийн Яаманд хүргүүлж ажиллав.</li> <li>4. Хууль, журам, тогтоол шийдвэрийн ГТЛ-ийн 2025 оны 01, 02, 03 дугаар сарын биелэлтийг тус тус Хуулийн хэлтэст хүргүүлэн ажилласан. Сангийн сайдын 2025.01.23-ны өдрийн 18 дугаар тушаалаар батдагдсан “Монгол улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-г ханган ажилласан бөгөөд ГТЛ-ийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж ТОГ-д хүргүүлсэн.</li> <li>5. УИХ-ын 2022 оны 36-р тогтоол “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээ”-г хэрэгжүүлэн ажилласан бөгөөд тайлант хугацаанд ГТЛ-д хийгдсэн ажлын хэрэгжилтийн тайланг ХХ-д хүргүүлсэн</li> </ol> <p><u>Ил тод байдлыг хангах:</u></p> <p>1. Монголын үндэсний олон нийтийн телевизээс “Ногоон шошго” нэвтрүүлэгт “Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн</p>
---	---	-------------------------	---	---

				<p>үлдэгдлийг тодорхойлох магадлан шинжилгээний өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар ГТЛ-иос сурвалжилга бэлтгэсэн бөгөөд уг нэвтрүүлэг нь 2025.02.24-ний өдрийн 18:10 цагт МНВ сувгаар олон нийтэд цацагдан ил тод байдлыг ханган ажиллав.</p> <p>2. Дотоод хэргийн их сургуулийн шалгагчийн ангийн 25 оюутанд, МУИС-ийн бизнесийн сургуулийн гаалийн ангийн 3-4 курсын 24 оюутанд, АМГТГ-ын харьяа уул уурхайн лабораториудын 40 мэргэжилтуудэд ГТЛ-ийн үйл ажиллагааг танилцуулан сурталчилж ажилласан..</p> <p><b>Биелэлт: 100%</b></p>
8	Үүрэг биелэлт	даалгаврын Хэрэгжилт, Гүйцэтгэлээр,	1.Гаалийн удирдлагаас даалгаврын хэрэгжүүлэх. 2. Харьяа гаалийн газрын салбар лабораториудын хийх ажлын төлөвлөгөөг тухай гаалийн газартай хамтран боловсруулж батлах	<p>байгууллагын өгсөн үүрэг даалгаврын тухай бүр</p> <p>1.ГЕГ-ын удирдлагын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон холбогдох тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан. Гаалийн байгууллагыг төлөөлж ГТЛ-ийн дарга дараах хэлэлцүүлэгт оролцсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2025.01.29-30 АХБ-ХХААХҮЯ хамтран хооорнд "Мэдээлэл, хариу арга хэмжээний нэгдсэн системийг ашиглан бүтээгдэхүүний үнэ болон хүнсний ханган нийлүүлэдтэд мониторинг хийх боломж" сэдэвт семинар</li> <li>• Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэлэлцүүлэг</li> <li>• 2025.02.20нд "Хүнсний салбарын стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин" хэлэлцүүлэг</li> <li>• 2025.02.21нд "Хүнс, Хүрээлэн буй орчин, Барилга, Эмийн нэгдсэн" хэлэлцүүлэг</li> </ul> <p>Мөн бусад албан хаагчид дараах хэлэлцүүлэг болон ажлын хэсэгт орж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• "Тамхины хяналтын тухай хууль"-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ГТЛ-ийн дарга С. Цэрэнчимэд , дэд ажлын хэсэгт , шинжээч-ГУБ С.Баярдулам нар ажиллаж, нийт 4 удаагийн хуаол оролцсон бөгөөд бөгөөд гаалийн лабораторийн шинжилгээнд хамрагдсан тамхи, тамхин бүтээгдэхүүний талаар дэлгэрэнгүй тайлан,зөрчлийн</li> </ul>

			<ul style="list-style-type: none"> <li>• мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн.</li> <li>• 2025.03.10-03.31 хооронд “Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ гүйцэтгэх” ажлын хэсэгт ГУАБ Б.Мөнхцацral ажилан ГЕГ-ын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу БЦТ-ийн үйл ажиллагаанд Гаалийн лабораторийн дүгнэлтийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж, тайланг ХШУДАГ-т хүргүүлэв.</li> <li>• 2025.03.28нд зохион байгуулагдсан ГУАБ П.Мөнх-Эрдэнэ “Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалсны давуу тал, боломжууд” хэлэлцүүлэгт панелистаар орсон.</li> <li>- 2025 оны “Пестицидийн үлдэгдлийн хяналтын хөтөлбөр, төлөвлөгөөн”-нд хилийн гаалийн салбар лабораториудыг хүнсний чиглэээр чадавхижуулах, мэргэшүүлэх талаар холбогдох саналыг хүргүүлсэн.</li> <li>- “Сангийн яамнаас ГЕГ-ын 2024 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн тайллангийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 18 дугаар ажил болох “Хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний 4.16 дах заалт “Гаалийн салбар лабораторийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх ажлын хүрээнд “-д хийгдэх саналыг, тайлбарын хамт ГЕГ ХШҮ-д ГТЛ-ийн 2025.04.09-ний өдрийн 01720/44 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн.</li> <li>- Авлигатай тэмцэх газраас 2025.05.15-ны өдөр ирүүлсэн 05/9358 дугаар “салбар лабораторийн байршил, байгуулагдсан эрх зүйн үндэслэл ирүүлэх тухай” албан бичгийг хүлээн авч холбогдох тайлбарыг нотлох баримтын хамт гаргаж ГЕГ-ын 2025.05.20-ны өдрийн 01/2118 дугаар албан бичгээр хүргүүлэн ажиллав.</li> </ul> <p>2. Нийт 163 албан тоотоор үүрэг даалгавар, зөвлөмж хүргүүлж, мэргэжил арга зүйгээр ханган, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Үүнд: дүгнэлт сунгасан-63, дахин дээжлэлт-38, гадаад дотоод хяналт-17, бусад-26 албан бичиг эзэлж байна.</p>
--	--	--	--

				<p>Мөн ГЕГ-ын ЗББНДБ-ын 148 дотоод зурваст хариуг хүргүүлж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд гаалийн газар хороодоос 163, яам, тамгын газар, агентлагаас 36, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 159 ирүүлсэн албан бичгийг хүлээн авч шийдвэрлэн, албан бичгээр хариуг хүргүүлж ажилласан.</p> <p><b>Биелэлт: 100%</b></p>
9	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллах	<p>1. ГПЛ нь MNS ISO/IEC 17025:2018 "Сорилт болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" стандартын 8.5 дугаар заалтын дагуу MNS ISO 31000:2017 "Эрсдэлийн менежмент. Зарчим ба заавар", MNS ISO 31010:2017 "Эрсдэлийн менежмент. Эрсдэлийн менежментийн арга" стандартууд болон ГЕГ-ын даргын 2022 оны А/342 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-ыг эш татан Ж805 дугаартай "Гаалийн лабораторийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх дотоод журам"-ыг боловсруулан, баталж, мөрдөн ажиллаж байна.</p> <p>Дээрх Ж805 дугаар журмын дагуу 2024 онд 9 эрдслийг тогтоон "ГААЛИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ЭРСДЭЛИЙН БҮРТГЭЛ" -д бүртгэж, "ЭРСДЭЛИЙН БҮРТГЭЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ"-г боловсруулан, бүртгэгдсэн эрсдэлүүдийг бууруулах арга хэмжээ авч ажиллан, "ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ"-ийг бүртгэлжүүлэн баримтжуулж, ажилласан бөгөөд үүний үр дүнд албан хаагчдын шударга байдлын эрсдэл өндөр байгааг дүн шинжилгээ хийж, 2025 онд Шударга байдлын эрдсийн үнэлгээг тусгайлан авч үзэж (Шударга байдлын эрслийн үнэлгээг хавсаргав) дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шударга байдалтай холбоотой үүсэх эрсдлийг бууруулах зорилгоор лабораторийн бүх албан хаагчдаар шударга байдлын мэдэгдлийг гаргуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулан, холбогдох эрх зүйн зохицуулалтыг хийж, ажиллаж байна.</li> <li>- Магадлан шинжилгээний үр дүнгийн чанар хангалттай</li> </ul>

				холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор үндэсний болон олон улсын ур чадварын сорилт (УЧС)-ын хөтөлбөрт хамрагдахаар хүсэлтийг илгээн, зөвшөөрсөн хариу хүлээн авч, хөтөлбөрийн хураамжийн санхүүжилтыг шийдвэрлэхээр ажиллаж байна.
10	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг Үүргийн хэрэгжилт/дотоод гадаад хяналт, ур чадварын хөтөлбөрт хамрагдах/	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1. Гаалийн төв болон салбар лабораториудын шинжилгээний үр дүнгийн чанар хангалтыг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоод хяналтыг улирал бүр зохион байгуулах, лабораторийн үр чадварын сорилтод төлөвлөгөөний дагуу хамрагдах, Шинжилгээний зөрүүг стандарт хязгаараас хэтрэхгүй байлгах,</p> <p>2. Гаалийн төв лабораторид дотоод аудитыг ISO 17025: 2018 стандартын дагуу зохион байгуулж, үл тохиролыг запруулах арга хэмжээг авч ажиллах.</p>	<p><b>Биелэлт: 90%</b></p> <p>2025 оны Гаалийн төв болон салбар лабораториудын шинжилгээний үр дүнгийн чанар хангалтыг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоод хяналт хийх хуваарь боловсруулж батлуулан, нийт 29 дээжид 15 удаа зохион байгуулж , хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.</p> <p>1. <u><b>Дотоод, гадаад хяналт:</b></u></p> <p>1.1 Дотоод хяналтыг нүүрс-2, хайлуур жоншны-10, зэсийн баяжмалын-2, тамхи, тамхин бүтээгдэхүүний-5, согтууруулах ундаа-6, ноос ноолуур, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн-3, химийн бодис-9, нефтийн бүтээгдэхүүн-6 буюу нийт 43 дээжид, мөн гаалийн салбар лабораторийн хяналтыг,</p> <p>1.2 гадаад хяналтыг "Эрдэнэт-Үйлдвэр" ТӨҮГ, SGS-IMME, "Ханлаб" ХХК, Jiaofeng (Bai Da) Textiles, "Эрдэнэт хивс" ХХК-уудтай буюу нийт 29 дээжид 15 удаа зохион байгуулж, үр дүн харьцуулан анализ хийсэн бөгөөд хэмжлийн зөрүү стандартад заасан хэмжээнд байлаа.</p> <p>2. <u><b>Ур чадварын сорилт (УЧС)-ын хөтөлбөр:</b></u></p> <p>2.1 "Геологийн судалгаа шинжилгээний төв" ТӨҮГ-аас CGL PT01 НҮҮРС "УЧС-ын хөтөлбөр"-ийн 14-р тойрогт нүүрсний шинжилгээгээр хамрагдахаар хүсэлт илгээн, дээжийг хүлээн авч, шинжилж,, үр дүнг тус төвд цахимаар хүргүүлэн, зохион байгуулж ажилласан.</p> <p>2.2 БНХАУ-ын NIL Research Center for Proficiency Testing байгууллага руу хүсэлт илгээж, ГТЛ-ийг бүртгүүлэн, зэсийн баяжмал, хайлуур жонш, төмрийн хүдрийн дээжид хамрагдах, БНХАУ-ын ЧИНХУАНДАО-ын УЧС-ын хөтөлбөрт нүүрсний техник үзүүлэлт болон хорт элементийн</p>

				үзүүлэлтээр тус тус хамрагдахаар хүсэлт илгээсэн.  3. Хятадын итгэмжлэлийн болон Үндэсний итгэмжлэлийн байгууллагаас 2 удаа хөндлөнгийн аудит орсон тул гаалийн төв лабораториид дотоод аудитыг ISO 17025: 2018 стандартын дагуу 4-р улиралд зохион байгуулахаар ажиллуулж байна.
11	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	1. Албан хаагч нарын ажиллагсадын цаг ашиглалтад хяналт тавьж ажлын цаг ашиглалтыг сайжруулж ажиллах, 2. Гаалийн төв лабораторийн шинжээч-гаалийн улсын байцаагч нарыг хор саармагжуулах бүтээгдэхүүнээр ханган ажиллах,	<b>Биелэлт: 90%</b>  1. Тайлант хугацаанд ГТЛ-ийн 22 ажиллагсад нь 20.416 цаг ажиллахаас: ажилласан цаг -20.806, илүү цагаар ажилласан-3022, өвчтэй цаг-40, ээлжийн амралттай-216, чөлөөтэй цаг-352, албан томилолтоор-1344, сургалтад хамрагдсан-72 тус тус эзэлж байна. ГТЛ-ийн ажиллагдын ажилласан цагийг нүүр таних программаар өдөр бүр бүртгэж, ажилласан цагийн тооцоог гарган, ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажилласан. 2. Гаалийн төв лабораторийн шинжээч-гаалийн улсын байцаагч нарын хөдөлмөрийг хэвийн бус, хүнд нөхцлөөр тооцож, ажлын богиносгосон цагаар ажиллуулах, амралтын хоногийн нэмэгдлийг тухай бүр тооцож, хөдөлмөр хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах гэрээг шинээр байгуулсан. Хор саармагжуулах бүтээгдэхүүний тайлан мэдээг тухай бүр ИТААҮГ-т хүргүүлж ажилласан. 3. ГТЛ-ийн нийт 19 ГУБ-шинжээч нарын хийсэн ажлыг сар бүрээр гарган үнэлж, хамт олны хурлаар авч хэлэлцэн, холбогдох материалыг ТЗҮГ-т хүргүүлсэн.
	<b>Нийт дундаж оноо</b>			<b>Биелэлт: 100%</b>  <b>Биелэлт: 97,27%</b>

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ГААЛИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ДАРГА

С.ЦЭРЭНЧИМЭД

ГААЛИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ДАРГА С.ЦЭРЭНЧИМЭДИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС  
ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн өрөнхий газар  
Нэгжийн нэр: Гаалийн төв лаборатори

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		61,2

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Гаалийн хэргийн болон магадлан шинжилгээний чиглэлээр сургалтад хамрагдаж, ур чадвараа дээшлүүлэх		15
2.	УУЭБЯ болон Монголын химийн инженерийн холбооноос хамтран зохион байгуулах "Химийн зөвлөх инженерийн зэрэг олгох" сургалтад хамрагдах		15
Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:			15

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	12
2.	Удирдан зохион байгуулах	13
3.	Асуудал шийдвэрлэх	12
4.	Манлайлах	12
5.	Багаар ажиллах	12
6.	Харилцаа	11
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		12

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	61,2
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	12
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	—
<b>Нийт оноо=</b> (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		88,2

**Үнэлгээ өгсөн:**

Гаалийн ерөнхий газрын дарга

**Төсвийн шууд захиратч:**

(Р. Отгонжаргал)

2025.06.25..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

Гаалийн төв лабораторийн

**Нэгжийн дарга:**

дарга

(С. Цэрэнчимэд)

2025.06.10..... (огноо)